## ХУРАЛДААНЫ ТОЙМ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
## 2015 ОНЫ ХОРИН ХОЁРДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны зургаадугаар сарын 18-ний 14 цаг 16 минутад эхэлж, 15 цаг 58 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 42 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Бийцээгийн Үнэнбатыг Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 2 | Уул уурхайн яамны зарим удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай<br>- Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар<br>- Түлшний бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Охиндойн Цэндсүрэнг Уул уурхайн |

| | | |
|---|---|---|
| 3 | | яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Артагт санал болгохтухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Лхамаасүрэнгийн Раднаасүрэнг Уул уурхайн яамны Түлшний бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Артагт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 3 | Зарим албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай<br>- Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирлын албан тушаалд томилогдох<br>- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Шүүхийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох<br>- Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох | Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайханы 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 03/861, 03/864 тоот албан бичгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирлын, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Шүүхийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон |

| | | |
|---|---|---|
| | - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох<br>- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухааны бодлого зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох<br>- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёлын бодлого зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох<br>- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санхүү, эдийн засгийн газрын даргын албан тушаалд томилогдох | шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.<br>Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Мягмарсүрэнгийн 2015 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 266 тоот албан бичгээр Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.<br>Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөлийн дарга Ш.Булга-Эрдэнийн 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 27 тоот албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын, Шинжлэх ухааны бодлого, зохицуулалтын газрын даргын, Санхүү, эдийн засгийн газрын даргын, Соёлын бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ. |